



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар A/533

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 102
дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2,310,000.00 (хоёр сая гурван зуун арван мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг нийслэлийн ерөнхий боловсролын 155 дугаар сургуулийн баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг нийслэлийн ерөнхий боловсролын 102 дугаар сургууль (Г.Гүнбаяр)-д зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг нийслэлийн ерөнхий боловсролын 155 дугаар сургууль (Д.Болд)-д даалгасугай

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 12 дугаар сарын 26 -ны
өдрийн 81 дугаар тушаалын хавсралт

Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 102 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Бүртгэх үнийн дүн		Шилжүүлэн авах байгууллага
										Нэгж үнэ	Нийт үнэ	
1	2-р хоолны тогоо /100 литрийн/	Орос	2010.12.31	ш	1	2,310,000.00	2,310,000.00	2,310,000.00	-	500,000.00	500,000.00	Нийслэлийн ерөнхий боловсролын 155 дугаар сургууль
	Тоног төхөөрөмжийн дүн						2,310,000.00	2,310,000.00	-	500,000.00	500,000.00	